

Зах зээлийн харилцаанд шилжих үеийн баруун аймгийн хүн ам зүйн зарим онцлог (Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн жишээн дээр)

Г.Нямдаваа

МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн захирал. Дэд проф

М.Баянтөр

МУИС-ийн Газарзүй, аялал жуулчлалын тэнхимийн эрхлэгч, проф

Ч.Нармандах

МУИС-ийн Ховд дахь салбар, магистр

Манай орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулж, цаашдын хөгжилд аль болохоор эрсдэл багатай хүрэх арга замыг тухайн орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэхэд тухайн бүс нутгийн хүн ам зүйн судалгааг явуулж, нийгмийн амьдралд гарч байгаа өөрчлөлтийг бүрэн мэдрэх явдал чухал ач холбогдолтой.

Ховд, Увс, Баян-өлгий аймгуудын хүн амын газарзүйн судалгаа явуулж үзэхэд дараах онцлог зүй тогтол илэрч байна.

1. Хүн амын тоо ба өсөлт, байршилт

Баруун гурван аймагт 1996 оны байдлаар улсын бүх хүн амын 12,1 хувь буюу 286300 хүн ам оршин сууж байна. Хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх талаар төр засгаас хэрэгжүүлж ирсэн бодлогын үр дүнд 1950-иад оноос хойш хүн амын өсөлт жилээс жилд тогтвортой нэмэгдэн, ихээхэн хурдацтай өсөж ирсэн бөгөөд 1990 оноос эхлэн өсөлтийн хурд буурч, 1992-1993 онуудад хамгийн доод түвшинд хүрээд, сүүлийн 2-3 жилд дахин бага зэрэг нэмэгдэн тогтворжих хандлагатай болов. Зарим судлаачдын үзэж байгаагаар улсын хэмжээнд, хүн амын төрөлт сүүлийн 4 жилд 30 гаруй жилээр ухарч, 1965 оны түвшинд хүртэл буурав.

Сүүлийн жилүүдэд үнэ өртгийн өсөлт, өргөн хэрэглээний бараа таваарын хомсдол, худалдаа, ахуйн үйлчилгээний зогсонги байдал, эмнэлгийн үйлчилгээ төлбөртэй болсон зэрэг хөдөөгийн хүн амд учирч байгаа нийгэм, эдийн засгийн бэрхшээл, үр хөндөлт нэмэгдэж байгаа зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой хүн амын өсөлт ийнхүү эрс буурсан хэдий ч улсын дунджаас дээгүүр хадгалагдаж байна. Тухайлбал: 1996 оны байдлаар 1000 хүн амд оногдох жилийн дундаж цэвэр өсөлт Баян-Өлгийд 23.8, Увсад 22.4, Ховдод 21.8 байгаа нь улсын дунджаас 9.1-7.1-ээр олон, 1000 хүнд ногдох төрөлт дунджаас 9.2-6.1-ээр тус тус илүү, нас баралт Баян-Өлгийд 7.5, Увсад 7.8, Ховдод 7.0 байгаа нь улсын дундажтай ойролцоо байна.

Энэ бүс нутгийн хүн амын цэвэр өсөлт өндөр байгаатай уялдаж нийт хүн амын насны бүтцэд ихээхэн өөрчлөлт гарч, 16-аас доош насны хүүхдийн

эзлэх хувийн жин нэмэгдэн Баян-Өлгийд 45.8 хувь, Увсад 42.5 хувь, Ховдод 41.8 хувь байгаа нь улсын дунджаас нэлээд өндөр үзүүлэлт юм.

Хүн амын төрөлтийн тоо баруун аймгуудын олон ястан, угсаатнуудын дотор харилцан адилгүй байна. Тухайлбал Баян-Өлгий аймагт 7-9 хүүхэд төрүүлсэн эхчүүдийн эзлэх хувь нийт хүүхэд төрүүлсэн казак эхчүүдийн 51.6 хувь, урианхай эхчүүдийн 36.6 хувь, дөрвөд эхчүүдийн 35.6 хувь байхад тува эхчүүдийн 6.9, бусад ястан эхчүүдийн дөнгөж 3.5 хувийг тус тус эзэлж байна. Эндээс үзэхэд олон хүүхэд төрүүлсэн казак эхчүүдийн эзлэх хувь нэлээд өндөр байгаа нь үндэс угсаагаа хадгалан үлдээх гэсэн үндэсний цөөнхийн хүсэл сонирхол, уламжлал, нас өндөр болоход асран хамгаалуулдаг, гэр бүл ах дүүстээ тусалж дэмждэг ариун сайхан ёс хадгалагдаж байгаатай холбоотой.

Улсын хэмжээнд эдгээр аймгууд нь хөдмөрийн нөөц хангалттай аймгуудын тоонд орох бөгөөд сүүлийн жилүүдэд Улаанбаатар болон бусад хот руу болон ихэвчлэн Баян-Өлгийгөөс Казакстан улс руу шилжих явдал нэмэгдэх болсонтой холбоотой хүн амын тоонд механик хөдөлгөөн багагүй гарч, өсөлтөнд сөргөөр нөлөөлөх нэг үндсэн хүчин зүйл боллоо.

Дээрх гурван аймгийн нутгийн нэг ам км талбайд дунджаар 1.5 хүн оногдож байгаа нь улсын дундаж нягтшилтай ойролцоо боловч тухайн бүсийн аймаг сумуудаар харилцан адилгүй байна. Тухайлбал: Увс аймгийн Хархираа, Ховд суманд 1 ам км талбайд 2.6-2.4 хүн оногдож байхад, Увс аймгийн Давст, Завхан сумуудад 0.3-0.4, Ховд аймгийн Мянгад, Ховд сумуудад 1.5 хүн, Алтай суманд 0.2 хүн оногдож, даруй 7-8 дахин зөрөөтэй байна.

Энэ бүсэд 1976 онд байсан 46 байнгын суурингийн 6 нь 500 хүртэл хүн амтай, 24 нь 501-1000, 9 нь 1001-1500, 4 нь 1501-2000, 3 нь 2001-ээс дээш хүн амтай байсан бол 1996 оны байдлаар 47 суурингийн 8 нь 5000-10000, 38 нь 2001-5000, 1 нь 2000 хүртэл хүн амтай болж нэмэгджээ.

Нийт хүн амын 29 орчим хувь нь хотод, 70 орчим хувь нь хөдөөд суудаг. Хотын статус бүхий суурин 3 (Өлгий, Ховд, Улаангом) бөгөөд цөм 20 гаруй мянган оршин суугчидтай бөгөөд хүн амын тоогоор Увс аймгийн төв Улаангом хот тэргүүлдэг (1996 оныхоор 29000 хүн амтай байв.) бүтцээр авч үзвэл хөдөлмөрийн насны хүн ам хотод, тэтгэврийн насны хүн ам хөдөөд илүү байна. 0-15 насны хүүхдийн эзлэх хувийн жин хөдөөд өндөр байгаа нь энэ насны хүүхдүүд 1990-ээд оны эхээр сургуулиа орхин мал дээр гарах явдал нэмэгдсэнтэй холбоотой.

Газар тариалан эрхэлдэг сумын төвүүдэд хүн амын тоо их, нягтшил нь харьцангуй өндөр байхад мал аж ахуй дагнан эрхэлдэг сумуудын төвд хүн ам бага суурьшсан зүй тогтол ажиглагдана.

2. Хүн амын шилжилт

Баруун бүсийн хэмжээнд эдийн засгийн дэд бүтцийн хөгжил сул, нийгэм соёлын үйлчилгээ хангалтгүй, төв суурин газраас алслагдсан, зах зээлийн хүнд

нөхцөлд олон янзын бэрхшээл тулгарсан зэрэг хүчин зүйлүүд нөлөөлснөөр төвийн бүсийн томоохон хотууд, түүний дотор нийслэл Улаанбаатар хот руу шилжин суурьших нь ихэд нэмэгдэж байна. Ялангуяа хүн амын дотор гол төлөв залуучууд Улаанбаатар болон бусад төв суурин газар шилжин суурьших явдал олширч, өндөр мэргэжил, боловсролтой иргэд соёл боловсролын төв бараадан шилжих үзэгдэл нэмэгдсэн нь төвлөрлийг сааруулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх боловсон хүчний нөөцөд муу нөлөөтэй юм.

Баруун гурван аймгийн олон ястнуудын дотор казак угсаатны шилжилт аль ч үед өндөр байсан байна. Социализмын үед төр засгийн бодлогоор шинээр байгуулагдсан хот, үйлдвэр уурхайнуудад олноор очиж байсны гадна хүн амын хурдан өсөлтийн улмаас Баян-Өлгий аймагт хөдөлмөрийн нөөц илүүдэлтэй болж, зэргэлдээх Ховд, Увс аймгуудын сумуудад шилжин суурьших нь элбэг байв. 1991 оноос хойш Казакстан улстай 5 жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан, баруун аймгууд төдийгүй улс орны хэмжээнд казак угсаатны томоохон шилжилт эхэлсэн бөгөөд үүний дүнд эерэг, сөрөг олон үр дагавар гарч байна. Шилжилтийн хүнд үед олон өрх айл амьдралын баталгаа болж байсан мал, хөрөнгөө худалдан замын зардал болгон нүүдэл хийж, шилжин очсон айл бүхэнд шинэ газар нутагт дасах нь амаргүй байснаас багагүй хэсэг нь түүний дотор өвгөд, хөгшид, хүүхэд олонтой хэсэг нь голдуу идээшин дассан Монгол нутгаа зорьж, хугацаанаасаа өмнө буцаж ирсэн бол ихэнх айлууд иргэний харьяаллаасаа гарч бүрмөсөн суурьших болжээ. 1991-1995 онд Баян-Өлгий аймгаас Казакстанд нийт 48736 хүн явж, 4294 хүн ирсний 91.7 хувь нь 1992-1993 онуудад явсан хүн байв.

1998 оны эхний байдлаар Казакстанд байгаа Монголын харьяат 60-аад мянган иргэнээс 10000 нь Монголд буцаж ирэх хүсэлтэйгээ илэрхийлжээ. Судалгаанаас харахад сум, аймгуудын удирдлагууд нь хүн амын шилжилтийн бодит байдлыг анзаарахгүй, энэ асуудлыг шийдвэрлэх талаар ямар нэг тодорхой зорилго, чиглэл бодлогогүй, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй, төвөөс явуулж байгаа хүн ам зүйн бодлого амьдралд үр өгөөжөө өгөхгүй байна.

Манай улсын 20 гаруй ястны 10 гаруй нь эдгээр аймгийн нутагт оршин суудаг. Түүхийн хөгжлийн явцад угсаатан ястан бүрийн нөхөн өсөлт, байршилт, шилжилт зэрэг хүн ам зүйн үзүүлэлтүүд нь харилцан адилгүй байсны улмаас аймаг, орон нутагт эзлэх хувь хэмжээ нь өөрчлөгдөж ирсэн байна. Тухайлбал: Ховд аймгийн угсаатан ястны бүтцийн өөрчлөлтийн явцаас үзэхэд 1944 онд халх ястнууд аймгийн нийт хүн амын 39.2 хувийг эзэлж байсан бол 1989 онд 25.6 хувийг эзлэх болж хамгийн их буурсан байхад казак угсаатан 3.2 хувийг эзэлдэг байснаа 16.3 хувийг эзлэх болж хамгийн их өссөн байна. Энэ хооронд дөрвөд ястны эзлэх хувь бага зэрэг багасан бусад угсаатны хувь бараг өөрчлөгдөөгүй тогтвортой хадгалагдаж үлдсэн байна.

3. Хүн амын амьдралд гарч буй зарим өөрчлөлт

Сүүлийн жилүүдэд баруун аймгуудын ард түмний амьдралд гарч байгаа өөрчлөлтүүдээс хамгийн эмзэг асуудал бол амьжиргааны түвшин буурч, ядуурал ихсэж байгаа явдал юм.

Монгол улсын хэмжээнд тогтоосон амьдралын түвшинг харгалзан үзэж нийтээр мөрдөж байгаа аргачлалаар тооцож гаргасан судалгаанаас харахад 1997 оны эхний 6 сарын байдлаар Баян-Өлгий аймагт 5349 ядуу өрх бүртгэгдсэний 2051 нь нэн ядуу, нийт ядуу өрхийн гишүүдийн тоо 25113 үүнээс 10886 нь нэн ядуу байна. Увс аймгийн хэмжээнд 3733 өрхийн 18604 хүн ядуу, үүнээс 1900 өрхийн 8875 хүн нэн ядуу амьдарч байна. Нийт хүн амын 18.8 хувь нь ядуу, 8.9 хувь нь нэн ядуу амьдарч багаа нь улсын дунджаас 2-3 пунктээр их байна. Ядуу өрхийн 14.5 хувь нь ба 544 нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй, 22.4 хувь нь буюу 839 нь 0-15 насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, 19.1 хувь нь буюу 713 өрх ажил эрхэлдэг хүнгүй байна.

Ядуурлын түвшингийн үзүүлэлт эдгээр аймгийн сумуудад харилцан адилгүй байх ба Баян-Өлгий аймгийн Цагааннуур суманд хамгийн өндөр үзүүлэлт буюу нийт хүн амын 65.4 хувь нь ядуу гэж үзсэн байхад энэ үзүүлэлт Ховд аймгийн Алтай суманд хамгийн бага буюу нийт хүн амын 2.8 хувь нь ядуу гэж тооцжээ. Ийнхүү өөр хоорондоо хэт их ялгаатай байгаа нь нэг талаас нутаг дэвсгэрийн ялгаатай байдлыг үзүүлэх боловч нөгөө талаас хүн ам зүйн зарим ойлголт нэг мөр болоогүй, гаргаж байгаа статистик мэдээнд алдаа их байдгийг гэрчилж байна.

Хөдөөд амьдралын түвшин ард түмний амьжиргааны гол эх үүсвэр болсон малын тоо толгойн өөрчлөлтөөс тодорхой харж дүгнэлт хийж болно. Тухайлбал: Ховд аймгийн Мянгад сумын өрхүүдийн малын тооны өөрчлөлтийг харахад 1995-1996 онд 201-500 толгой малтай, амьдралын нөхцөл бололцоотой өрхийн тоо 192 байснаа 163 болж 29-өөр буурсан байхад, 11-30 толгой малтай нэн ядуу малтай өрхийн тоо 24-өөр нэмэгдсэн байна.

Эдгээрээс дүгнэлт хийж үзвэл улс орон нийгмийн нэг байгууллагаас нөгөөд шилжиж байгаа үед төр засгаас "зоригтой" шийдвэрлэх олон зүйл байх боловч ард түмний нэгэт хүрсэн амьдралын түвшингээс ухарч, ядуурал, үгүйрэл эрс нэмэгдэхэд нөлөөлж байгаа зарим бодлого шийдвэрийг хүн ам зүйн судалгааны зарим үр дүнд тулгуурлан шүүмжлэлтэй хандаж, засаж залруулж байх шаардлагатай байна.

Ядуурал нэмэгдэхэд нөлөөлж байгаа үндсэн бэрхшээлийн нэг нь хүн амын ажилгүйдэл юм. 1996 оны байдлаар эдгээр аймгуудын хөдөлмөрийн нөөц 127967 хүн байгаагийн 73.8 хувь нь ажил эрхэлж, 8.7 хувь нь суралцаж, 17.5 хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна. Хөдөлмөр эрхэлж буй байдал Ховд аймагт илүү өндөр, Баян-Өлгийд хамгийн бага үзүүлэлттэй байхад, суралцагсдын эзлэх хувь Баян-Өлгийд өндөр байна.

Эдгээр аймгуудад байгаа ажилгүйчүүдийг боловсролын байдлаар авч үзэхэд дээд, тусгай дунд боловсролтой ажилгүйчүүдийн тоо харьцангуй

тогтвортой байхад, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ЕБС, ямар нэг дамжаа төгссөн ажилгүйчүүдийн эзлэх хувь өндөр, жилээс жилд нэмэгдэж байна. Энэ нь дээд боловсролтой хүмүүс төрийн байгууллагад ажилд орохоос гадна ямар нэгэн байдлаар хувиараа эрхлэх аж ахуй, бизнес эрхлэх чадвар илүү байхаас гадна тусгай мэргэжлийн сургууль, дамжаа, ЕБС төгсөгчид амьдралаа шинээр эхэлж, идэвхтэй ажил эрж байдагтай холбоотой.

Хүний хүчин зүйлийг бүрэн дүүрэн ашиглах замаар нийгмийн асуудлыг шийдвэрлэх чухал нөхцөлийн нэг нь ард түмний боловсролын түвшин юм.

Сүүлийн жилүүдэд улс орны хэмжээнд гарсан нийгэм эдийн засгийн хямрал нь төвөөс алслагдсан баруун аймгуудын боловсролын салбарын үйл ажиллагаанд ихээхэн сөрөг нөлөөллийг үзүүлэв. Тухайлбал: Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн хэмжээнд хүүхдийн цэцэрлэг, сургуулийн санхүүжилт, түлш, хоол хүнс болон бусад материаллаг нөхцлийн хэвийн байдал эрс алдагдсанаас дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хүнс, тэжээлийн чанар хүртээмж муудаж, үнийн өсөлт, мөнгөний ханшны уналттай холбогдон малчид, хөдөлмөрчдийн амьжиргааны түвшин буурч, хүүхдийнхээ хувцас, хичээлийн хэрэглэл олж авч чадахгүйд хүрч, өмч задарч амины аж ахуйд, ялангуяа мал аж ахуйд ажиллах хүч шаардлагатай болсон зэрэг бодит шалтгаан түүнчлэн ард иргэд боловсролын хэрэгцээ үнэ цэнийг дутуу үнэлэх болсон зэргээс хамаарч сургуулиас хүүхэд завсардах нь эрс өслөө.

Нөгөө талаас хөдөө нутагт багш нарын тоо цөөрч, салбарын цалин хөлс багасч, ажиллагсад сэтгэл санааны дарамтад орж, сургалтын материал хомсдсон зэрэг боловсролын салбарт тохиолдож байгаа бэрхшээлүүд нь ихэнх нь нийгэм эдийн засгийн шилжилтийн үеийн бэрхшээлтэй холбоотой юм.

Шилжилтийн үед боловсролын системд тулгарч буй эмзэг асуудлын нэг нь сургууль завсардалт юм. Энэ асуудал ялангуяа өмч хувьчлал эхэлсний дараагаас хөдөө орон нутагт илүү ажиглагдах болсон байна. Эдгээр гурван аймагт ард түмний хүүхдийн сургууль завсардалт 1994-1995, 1995-1996 оны хичээлийн жилд буюу ганцхан жилийн дотор 1.8-6.4 дахин нэмэгджээ.

Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт гарч байгаа бас нэгэн сөрөг үзэгдэл бол ялангуяа хөдөөгийн сургуулиудад мэдрэгдэх болсон сургалтын чанарын бууралт юм. Энэ нь нэг талаас эцэг эхчүүдийн гарч байгаа санал, гомдол, нөгөө талаас суралцагсдаас авч байгаа шалгалтын дүн, хөдөөгийн сургуулиудаас их, дээд сургуульд элсэгчдийн эзлэх хувь, тэдгээрийн бэлтгэлийн чанарын байдал зэргээр батлагдаж байна.

Хөдөөгийн ард түмний дотор соёл, ахуйн үйлчилгээний ажил зогсонги байдалд орсныг сэргээн хөгжүүлэх хэрэгцээ бий болжээ. Одоогоор хөдөөгийн ихэнх сумуудад халуун ус, номын сан, номын худалдаа, кино үзвэрийн үйлчилгээ ажиллахгүй байгаа нь хүний хүчин зүйлийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай нэг чухал нөхцөл бүрдэхгүй байна.

Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад явуулсан хүн амын эдийн засгийн газарзүйн судалгааны явцаас дүгнэлт хийж, дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

1. Ядуурлыг бууруулах талаар төр засгаас явуулж ирсэн үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ орон нутгаас нэмэлт шуурхай арга хэмжээ авах, ард түмний зах зээлийн эдийн засгийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх талаар сургалт, сурталчилгааны ажлыг өргөнөөр зохиох

2. Зах зээлийн харилцааны зүй тогтол, орон нутгийн нөхцөлд тохирсон бүс нутгийн бодлогыг цаг алдалгүй боловсруулан хэрэгжүүлэх, төр засгаас авч явуулж байгаа нийгмийн асуудалтай холбогдсон шийдвэрүүдэд иргэдийн төлөөлөөр дамжуулан тухайн онцлогийг тусгуулж байх

3. Орон нутгийн өөрийн дотоод нөөц бололцоог ашиглан хүн амын эмзэг хэсэг, нэн ядуу өрхийн орлогыг нэмэгдүүлэх, хөдөөгийн ядуучуудыг малжуулах, газар тариалан, жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эмнэлэг, үйлчилгээний боломжийг өргөжүүлэх, эмнэлэг, боловсрол, соёлын үйлчилгээг хүртээмжтэй болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх

4. Хүн ам зүйн судалгааны асуудлаар нэгдсэн ойлголт, арга зүйг боловсруулах, аймаг бүрт ажиллаж буй хүн ам зүйн мэргэжилтнүүдийн сургалт, судалгааг сайжруулж, нэгдсэн аргачлалаар хангах

5. Зах зээлийн нийгэмд хаана амьдрах нь иргэн бүрийн эрх боловч бүс нутгаа хөгжүүлэхэд хүний хүчин зүйл шийдвэрлэх нөлөөтэй болохыг анхааран иргэд, нэн ялангуяа мэргэжил боловсролтой боловсон хүчнүүд тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүн амын шилжилт нь ямар нэг сөрөг үр дагаварт хүргэхгүй, харин ч төвлөрлийг сааруулж, бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд эерэгээр нөлөөлөхүйцээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх

6. Түүхэн үеийн турш хадгалагдан ирсэн олон угсаатны ёс заншил, соёлыг хойч үедээ өвлүүлэн үлдээх талаар анхаарахын зэрэгцээ ургийн бичгийг сайтар хөтлөн, үр удмаа чанаржуулан үлдээх талаар анхаарах

Ашигласан материал:

1. М.Баянтөр, Б.Гунгаадаш, О.Сүхбаатар
БНМАУ-ын хүн амын газар зүйн зарим асуудалд УБ 1973
2. М.Баянтөр, Ч.Нармандах
Ховд аймгийн хүн амын газарзүйн асуудалд
МУИС-ийн хүн ам зүйн төвийн сэтгүүл 1997 он N1.
3. Г.Нямдаваа
БНМАУ-ын хөдөөгийн хүн амыг мужлах асуудалд
Ховд дахь УБДС-ийн эрдэм шинжилгээний бичиг 4-р боть УБ 1988
4. Монголын хүн ам зүйн судалгаа УБ 1997
5. Монголын хүний хөгжлийн илтгэл УБ 1997

